



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/578

Улаанбаатар хот

Салбар хороо шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 151 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах эрх үүрэг бүхий салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан зөвлөмж, хөтөлбөр, төлөвлөгөөг удирдлага болгон холбогдох арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хийсэн ажлын тайланг жил бүр зохицуулах зөвлөлд тайлагнаж байхыг салбар хороонд даалгасугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/46 дугаар "Салбар хороо шинэчлэн байгуулах тухай" тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

2018.09.13

Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 19 дүгээр сарын 13 -ны өдрийн
А/376 дугаар тушаалын хавсралт



Салбар хорооны бүрэлдэхүүн

- Дарга: Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга
- Гишүүд:
- Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны менежер
 - Нисэх буудлуудын удирдах газрын Захиргаа, удирдлага, санхүүгийн хэлтсийн захиргааны менежер
 - Захиргаа, удирдлагын газрын захиргааны мэргэжилтэн
 - Үйлчилгээ, аж ахуйн албаны Аж ахуйн тасгийн дарга
 - Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газрын үйлдвэрлэл хариуцсан менежер
 - Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны захиргааны менежер
 - Сэргээн засах амралтын захиргааны мэргэжилтэн
 - Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч
- Нарийн бичгийн дарга: Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын ахлах мэргэжилтэн

---oOo---